



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 84

Алтай

Хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “З” дахь заалт, “Агаарын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн “Агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв хөрөнгийг улс, орон нутгийн болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамруулж, хэрэгжилтийг зохион байгуулж жил бүр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Амгаланбаатар/ даалгасугай.

3. Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг сум орон нутагтаа зохион байгуулж, сумынхаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа жил бүр тайлагнаж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



А. ДЭЛГЭРЖАРГАЛ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2011 оны 12 дугаар сарын
10-ны өдрийн 84 дүгээр тогтоолын хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН АГААРЫН ЧАНАРЫГ
САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл, өнөөгийн нөхцөл байдал

Дэлхий нийтийн болон бүс нутаг, улс орнуудын тулгамдсан асуудлуудын нэг нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх асуудал бөгөөд хүний өдөр тутам амьсгалдаг агаарын аюулгүй байдал энэхүү асуудалд ихээхэн чухал байр эзэлдэг. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын бичсэн тайлангаас үзэхэд дэлхий нийтийн болон бүс нутгийн хэмжээнд хамгийн түгээмэл тохиолдож буй 10 эрсдэлт хүчин зүйлд бохир ус, эрүүл ахуй ариун цэвэр, агаарын бохирдол орж байна.

Манай оронд ч хүрээлэн буй орчинтой холбоотой хүний эрүүл мэндэд тохиолдож буй олон асуудлын нэгд агаарын бохирдол орно. Агаар нь байгалийн болон хүний хүчин зүйлийн улмаас хөдөлгөөнт болон суурин эх үүсвэрээс бохирдож байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд удаан задардаг органик бохирдуулагчид буюу диоксин, фуран нь агаарыг бохирдуулах болж Монгол улс төдийгүй олон улсын анхаарлыг татаад байна. Эдгээр бодис нь одоогоор шинжлэх ухаанд мэдэгдэж байгаа хамгийн хортой, аюултай бодис бөгөөд төрөл бүрийн шаталтын улмаас үүсч, хүний эрүүл мэндэд агаараар, хөрсөөр, идэш, тэжээлээр дамжин маш хортой нөлөө үзүүлдэг. Үүнийг дэлхийн эрдэмтэт “Чимээгүй тахал” гэж нэрлээд байна. Өөрөөр хэлбэл автомашин, үйлдвэр, цахилгаан станц, гэр хороолол, хог шаталтаас үүсэх утаа ихээр нэмэгдэж эдгээр эх үүсвэрүүдээс гарсан хүхэрлэг хий, азотын давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл, тоос, химийн хортой нэгдлүүд агаар орчныг бохирдуулж хүн амын эрүүл мэнд, амьдралын чанар, бүтээмжид сөргөөр нөлөөлөх явдал ихэссээр байна. Агаарын бохирдол нь байнга амьсгалын замаар хүний биед орж эрүүл мэндэд хурц болон архаг нөлөө үзүүлдэг бөгөөд энэ нь бохирдуулагчийн хэмжээ, өртөлтийн хугацаа, хувь хүний онцлогоос ихээхэн хамаардаг. Гэвч агаарыг бохирдуулагч бодисын үзүүлэлтүүд ДЭМБ-ын стандартаас бага байсан ч удаан хугацааны дараа хортой нөлөө үзүүлдэгийг анхаарахгүй орхих аргагүй юм.

Өнөө үед агаарын чанарыг сайжруулах замаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх нь нэн тэргүүний шаардлага болсон байна. Иймд аймгийн агаарын бохирдлыг хэвийн түвшинд барих, цаашид үүсэх бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаарын чанарын хяналтыг сайжруулах зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх зайлшгүй үндэслэл, шаардлагыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

а/ Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх явцад агаар, ус, хөрс, биологийн орчинд хохирол учруулах, түүнийг доройтуулахгүй байх гэсэн тогтвортой хөгжлийн дэлхий нийтийн гол зарчмыг баримтлан, ногоон хөгжлийг бий болгох;

б/ Аймгийн хөгжлийг дагаж байгалийн болон хүний үйл ажиллагааны нөлөөллөөс үүсэх агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарт орох өөрчлөлтийг харгалзан

үзэж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах замаар хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх;

в/ Цэвэр агаар нь зөвхөн нэг орны төдийгүй дэлхийн хэмжээний асуудал бөгөөд аливаа амьд биетийн оршин тогтнох зайлшгүй нэг нөхцөл нь болж байдаг төдийгүй дэлхийн бөмбөрцгийн дулааныг гадагш алдахгүй, нарны хорт туяанаас хамгаалах бамбай болдог учир агаарыг хамгаалж цэвэр байлгахад энэ дэлхийн хүн бүрийн үүрэг оролцоо их чухал юм. Иймд тэдгээрийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрт зөв ухамсар сэтгэлгээг төлөвшүүлэх олон талт бодитой ажил зохион байгуулах зэрэг шаардлагууд гарч ирж байна.

1.1. Говь-Алтай аймгийн агаарын чанар, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, агаарын чанарын хяналт, шинжилгээний өнөөгийн нөхцөл байдал:

Тус аймгийн 18 сум 2 тосгонд нийт 15578 өрх буюу 56208 хүн байгаагаас төв суурин газарт 56,4 хувь буюу 8790 өрх /32721 хүн ам/, хөдөөд 43,6 хувь буюу 6788 өрх /23487 хүн ам/ амьдарч байна. /2013 оны статистик мэдээнээс/

Дээрх 18 сумаас зөвхөн Есөнбулаг сум буюу аймгийн төв агаарын чанарын хяналтын харуултай, бусад сумд одоогоор агаарын чанарын хяналтын харуул байгуулагдаагүй байна. Иймд аймгийн төвөөс бусад сум суурин газрын агаарын бохирдлыг тодорхойлох боломж нөхцөл бүрдээгүй байна.

Улаанбаатар хотын агаарын бохирдолд нөлөөлж буй гол хүчин зүйлсийн судалгааны дүнгээс харахад 47.8 хувь нь тээврийн хэрэгслийн утаа, 40.3 хувь нь гэр хорооллын айл өрх, 5 хувь нь уурын зуух, 3.5 хувь нь дугуй хог шатаалт, 3,4 хувь нь тоосжилт гэсэн дүн гарсан байна. Харин манай аймгийн хувьд иргэдээс авсан асуулгын хуудасны дүнгээс харахад 41,7 хувь нь гэр хорооллын яндангаас гарах утаа, 29,2 хувь нь уурын зуухнуудын утаа, 16,7 хувь нь тээврийн хэрэгслийн яндангийн утаа, 12,5 хувь нь хог хаягдал, дугуй шатаалт, тоосжилт зэрэг бусад зүйл нөлөөлж байна гэсэн судалгаа гарсан байна.

2011 оноос эхлэн БОАЖ-ын сайдын 2011 оны А-131 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу агаар бохирдуулах эх үүсвэрийн тооллогыг хийж байгаа бөгөөд тооллогоор аймгийн хэмжээнд агаар бохирдуулах хөдөлгөөнт эх үүсвэр буюу тээврийн хэрэгсэл 11043, дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуух 209, технологийн болон тусгай зориулалтын зуух 4 /тоосго болон блок шатаах зуух/, агаар бохирдуулагч бусад эх үүсвэр 120, энгийн зуух бүхий 18755 өрх жилд 36683,6 тн орчим түлш/аргал, хөр, нүүрс, мод, шахмал түлш/ хэрэглэж байгаа дүн гарсан байна.

Хүснэгт. Говь-Алтай аймгийн 2014 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарын 04-ний өдрийн хооронд хийсэн тээврийн хэрэгслийн оношлогооны дүн

	Тээврийн хэрэгслийн төрөл							Дүн	Хөдөлгүүрийн төрөл					ДН	Тээврийн хэрэгслийн насжилт			Дүн
	Суу дал	Ачаа	Авт обус	Тусгай	Мотоцикл	Механизм	Дүн		Бинз	Дизель	Хий	Бусад	0-3 жил		4-9 жил	10 ба түүнээс дээш		
																	Дүн	
Сумын нэр	108	8	8	1	56	1	182	168	14	0	0	182	19	112	182			
Алтай сум	156						263											
Есөнбулаг	8	456	280	31	278	25	8	1854	711	14	60	9	307	2126	2697			
Баян-Уул	166	68	26	3	44	0	307	198	80	0	29	307	60	207	307			
Бигэр	69	29	11	1	53	1	164	122	38	4	0	164	19	103	165			
Бугат	117	25	16	1	67	0	226	204	22	0	0	226	28	140	228			
Гуулин тосгон	11	9	4	0	5	0	29	20	9	0	0	29	2	25	30			
Дарив	85	40	29	3	30	0	187	144	43	0	0	187	20	148	187			
Дэлгэр	68	49	17	1	75	0	210	146	63	0	1	210	18	129	210			
Жаргалан	100	23	7	2	74	1	207	182	24	0	1	207	13	125	208			
Тайшир	93	45	11	1	94	0	244	196	47	0	1	244	19	153	245			
Тонхил	101	53	29	3	15	0	201	131	70	2	0	203	18	173	202			
Төгрөг	87	33	9	0	48	0	177	140	35	1	0	176	17	118	177			
Халиун	83	49	6	1	179	1	319	258	58	0	2	318	28	135	319			
хөхморьт	72	8	10	0	5	0	95	80	13	1	2	96	4	78	95			
Цогт	140	24	23	1	60	0	248	215	32	34	0	281	12	184	249			
Цээл	177	87	27	116	28	49	484	188	262	10	0	460	136	188	617			
Чандмань	59	36	14	1	64	0	174	126	38	0	0	164	35	94	177			
Шарга	108	62	8	1	48	0	227	164	62	0	1	227	13	172	227			
Эрдэнэ	54	30	26	1	28	0	139	95	43	0	0	138	12	102	139			
Дүн	326	6	1134	168	1251	78	645	4631	1664	66	97	645	789	4512	6458			

Дээрх судалгааны дүнгээс харахад нийт тээврийн хэрэгслийн 69.86 хувь нь 10 буюу түүнээс дээш насжилттай, 12.2 хувь нь 4-9 жилийн насжилттай үлдсэн 17.94 хувь 3 ба түүнээс доош насжилттай байна. Тээврийн хэрэгслийн насжилтаас хамаарч тэдгээрээс гарах утаа агаарын бохирдолд нөлөөлсөөр байгаа бөгөөд олон улсын жишгээр тээврийн хэрэгслийн насжилт 6-8 жил гэж байдаг бол манай улсад 10 жилээс дээш насжилттай тээврийн хэрэгсэл ихэнх хувийг эзэлж байна.

Мөн 2013 онд удаан задардаг органик бохирдуулагчийн улсын тооллогын ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулсан. Энэхүү тооллогоор:

- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг 13 сум энгийн гар хийцийн зууханд, 4 сум ил задгай шатаадаг бөгөөд эдгээр нь жилд нийт 215,46 тн аюултай хаягдлыг шатааж, 80,4 тн үнс гаргадаг
- Уурын болон ус халаах 209 зуух жилд 15945 тн нүүрс хэрэглэж 4134 тн үнс, гэрийн зуух бүхий 18755 өрх жилд 36683,6 тн түлш хэрэглэж 18182,9 тн үнс гаргадаг
- Тоосго, блок хийдэг 3 аж ахуйн нэгж жилд дунджаар 4303 тн тоосго, блок үйлдвэрлэгдэг
- Аймгийн хэмжээнд 11043 тээврийн хэрэгсэл жилд дунджаар 20450,65 тн шатахуун хэрэглэж байгаа
- 2007-2011 онд тал хээрийн түймэр гараагүй бөгөөд 2010-2012 онд талын түймэр 2, гэр, орон сууц, хашааны түймэр 26, машин техникийн түймэр 8, 2013 онд ой хээрийн түймэр гараагүй, обектын түймэр 34 гарсан
- Биомассын хатаалт жилд 13808,2 тн /аргал, хөр, шахмал түлш түлдэг айл өрхийн жилд хэрэглэдэг түлшний хэмжээгээр гаргасан/
- Аймгийн хэмжээнд 23 хогийн цэг 257.16 га талбайг хамран тархаж, жилд 27231.8 тн хог төвлөрдөг гэсэн дүн гарсан байна.

Агаарын бохирдол нь өвчлөлийг нэмэгдүүлж, бие махбодын өсөлт, хөгжилт болон физиологийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөн, дархлалын түвшинг бууруулдаг. Манай аймгийн хэмжээнд цочмог халдварт өвчлөл, амьсгалын тогтолцооны өвчлөл, хоол боловсруулах эрхтний өвчлөл, шээс бэлгийн тогтолцооны өвчлөл, зүрх судасны өвчлөлөөр ард иргэд зонхилон өвчилдөг судалгааны дүн байна.

д/д	Өвчний нэр	10000 хүн амд		
		2011	2012	2013
1	Цочмог халдварт өвчлөл	113,5	77,2	49,2
2	Амьсгалын тогтолцооны өвчлөл	1222,3	1132,6	808,3
3	Хоол боловсруулах эрхтний өвчлөл	1407,9	1467	579,2
4	Шээс бэлгийн тогтолцооны өвчлөл	1215,8	1248,16	327,8
5	Зүрх судасны өвчлөл	1407	890	159,2

Хүснэгт-4. Говь-Алтай аймагт зонхилох өвчлөлийн судалгаа

АЛТАЙ ХОТЫН ХУВЬД :

Есөнбулаг сум нь 6 баг, 5058 өрх буюу 19053 хүн амтай, үүнээс төв суурин газарт буюу Алтай хотод 4771 өрх буюу 18018 хүн, хөдөөд 287 өрх буюу 1035 хүн байгаа бөгөөд өөрөөр хэлбэл нийт өрхийн 94,3 хувь төв суурин газарт, үлдсэн 5,7 хувь хөдөөд амьдарч байна./2013 оны статистик мэдээнээс/

Дээрх Алтай хотын төвд байгаа 4771 өрхийн 73,1 хувь буюу 3491 нь гэр хороололд ердийн галлагаатай 10 квт хүртэл хүчин чадалтай энгийн зуух бүхий байшин гэрт, 26,9 хувь буюу 1280 өрх төвлөрсөн халаалттай байшин хороололд амьдарч байна. Ердийн галлагаатай 10 квт хүртэл хүчин чадалтай энгийн зуух бүхий 3491 айл өрхийн зөвхөн 120 гаруй нь бүрэн шаталттай, түлш бага хэрэглэдэг, бохирдол бага гаргадаг зуухыг хэрэглэж байна. Нам даралтын зуух буюу 11-100 квт хүртэл хүчин чадалтай зуух 28 байгаа бөгөөд эдгээр нь яндангийн утаа шүүгчгүй, дотоодын хяналтын багаж хэрэгсэлгүй ажиллаж байна.

Алтай хот нь 2013 оны байдлаар нийт 11 км хатуу хучилттай зам, 3,5 км явган хүний замтай байсан бөгөөд хүн ам болон тээврийн хэрэгслээс шалтгаалан үүсч байгаа тоожилтыг бууруулах, хотын тохижилт, хүн амын амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2014 онд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

1. Баянхайрхан багт 1500 м, Харзат багт 500 м, Жаргалант багийн Сутай хорооны 900 м хатуу хучилттай авто замын дагууд 500 м, АУЭХС ТӨХК-ийн баруун талын 495 м, Ахмадын сувилал чиглэлийн 500 м, Эмнэлгийн уурын зуухны зүүн талын 112м, Шагай төвийн арын 117м, Миний байшин хотхонд 210 м цемент бетон хучилттай явган зам

2. Концессийн гэрээний дагуу Харзат багт 3 м-ийн өргөнтэй 652 м урт асфальтбетон хучилттай унадаг дугуйн замыг тус тус барьж гүйцэтгэсэн байна.

3. АУЭХС ТӨХК-ийн баруун талд 495 м, Ахмадын сувилал чиглэлд 500 м, Эмнэлгийн уурын зуухны зүүн талд 112 м, Шагай төвийн ард 117 м хатуу хучилттай авто замуудыг байнгын ашиглалтанд оруулсан байна. Мөн Жаргалант багт 1.8 км, Сутай хороонд 0.9 км авто замын барилгын ажлыг концессын гэрээгээр гүйцэтгүүлж, 0.9 км авто замыг байнгын ашиглалтанд оруулж, Шинэ хороололд 3.8 км хатуу хучилттай авто зам байгуулахаар төлөвлөн гүйцэтгэгчтэй гэрээ хийсэн.

4. Мөн 4-р байрны зүүн талд 1226 м², Холбооны гадна талд 2043 м², Нэгдсэн эмнэлгийн баруун талд 1900 м², Нэгдсэн захын баруун талд 1562 м², 21, 22-р байрны баруун талд 857м², Миний байшин хотхонд 1170 м², 19-р байрны зүүн талд 1022 м², Татварын хэлтсийн урд 490 м² хатуу хучилттай авто зогсоолыг хийсэн байна.

Алтай хотын ногоон байгууламжийн нийт талбай нь 12 га бөгөөд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн талбай 6,6 м² байна. Энэ нь стандарт хэмжээнээс 3,6 дахин бага байгаа бөгөөд стандарт хэмжээгээр аймгийн төвд одоогийн хүн амын тоогоор бодоход 43,24 га талбайд ногоон байгууламжтай байх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл ойрын 2-3 жилд багаар тооцоход 35 га талбайд ногоон байгууламж нэмж хийснээр стандарт хэмжээнд хүрнэ гэсэн үг. Ингэснээр тоосжилт болон агаарын бохирдлыг бууруулах нэг гол үндэс болох юм.

Агаарын чанарын мэргэжлийн албаны салбар "Агаарын чанарын хяналтын харуул"-ыг 2008 онд байгуулж, агаарын чанарыг судлах стандартын путк, тоног төхөөрөмжийг аймгийн МХГ-ын хашаанд суурилуулсан ажиллуулж байна.

Тус харуул нь өдөр бүр 08, 14, 20 цагуудад агаарт байгаа хүхэрлэг хий /SO/, азотын давхар исэл/NO2/- ийн хэмжээг тодорхойлж, аймгийн төвийн тогтоосон

зогсоол, цэгүүдэд агаар, хөрсний дээж авч бохирдлын шинжилгээг БОБХЗТЛабораторид явуулан хийлгэж, дүн мэдээг аймгийн удирдлагууд болон олон нийтэд 10 хоног дутамд мэдээлдэг. Тус шинжилгээний дүнгүүдээс харахад аймгийн төвийн агаар дахь хүхэрлэг хий /SO/, азотын давхар исэл/NO 2/- ийн хэмжээ нь хүрэлцэх хэмжээнээс бага дүнтэй байна.

**Агаарын чанарын харуулын сүүлийн 5 жилийн
шинжилгээний дүн**

Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2009	0,024	0,025	0,15	0,003	0,003	0,005	0,004	,007	0,004	0,004	0,006	0,007
2010	0,009	0,01	0,01	0,009	0,006	0,004	0,002		0,005	0,005	0,005	0,006
2011	0,007	0,006	0,005	0,004	0,004	0,003	0,003	0,003	0,003	0,003	0,007	0,013
2012	0,07	0,011	0,006	0,006	0,004	0,003	0,002		0,004	0,006	0,006	0,008
2013	0,009	0,008	0,006	0,005	0,005	0,002			0,004	0,018	0,027	0,005

Хүснэгт-1. Хүхэрлэгхийн сүүлийн 5 жилийн сарын дундаж агууламж

Он	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
2009	0,054	0,044	0,04	0,016	0,015	0,015	0,01	0,003	0,006	0,011	0,018	0,02
2010	0,021	0,021	0,017	0,013	0,01	0,012	0,01		0,008	0,018	0,019	0,023
2011	0,027	0,022	0,018	0,014	0,013	0,012	0,012	0,012	0,016	0,012	0,021	0,020
2012	0,019	0,02	0,015	0,012	0,011	0,01	0,009	0,012	0,017	0,019	0,019	0,015
2013	0,024	0,022	0,025	0,019	0,017	0,012			0,012	0,023	0,022	0,014

Хүснэгт-2. Азотын давхар ислийн сүүлийн 5 жилийн сарын дундаж агууламж

Он	SO ₂ мг/м ³	NO ₂ мг/м ³
Хүлцэх хэмжээ	0.45	0.085
2008 оны жилийн дундаж	0.016	0.042
2009 оны жилийн дундаж	0.008	0.022

2010 оны жилийн дундаж	0.006	0.016
2011 оны жилийн дундаж	0.005	0.017
2012 оны жилийн дундаж	0.012	0.014
2013 оны жилийн дундаж	0.011	0.015

Хүснэгт-3. 2009-2013 оны хүхэрлэг хий, азотын давхар ислийн жилийн дундаж, хүрэлцэх хэмжээний дүнг харуулав

Гэвч аймгийн төвийн агаарын бохирдлыг дан ганц хүхэрлэг хий /SO/, азотын давхар исэл/NO₂/- ийн хэмжээгээр төлөөлүүлэн үзэж болохгүй бөгөөд “Агаарын чанарын харуул” нь агаарт байгаа бусад бохирдуулагчийн хэмжээг гаргадаггүй, түүнчлэн бусад сумдын нутагт агаарын бохирдлын хэмжээг тодорхойлох боломжгүй байгаа нь өнөөдрийн бидний тулгамдсан асуудлын нэг болоод байгаа юм.

Дүгнэлт: Аймаг, орон нутгийн хөгжлийг дагаж агаар бохирдуулах эх үүсвэр жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаа учир тэдгээрээс уурын болон ус халаах зуухнуудын /нам даралтын зуухнуудын/ тоог цөөлөх, аймаг болон сумын төвд төвлөрсөн халаалтын системийг бий болгох, мөн бохирдуулагч эх үүсвэрүүдээс гарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах, цэвэршүүлэх, түүнчлэн аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд нь өвлийн улиралд түүхий нүүрс түлж байгаа нь агаарын бохирдлыг нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байгаа бөгөөд гэр хороолол буюу айл өрхөөс үүсэх агаарын бохирдол/утаа/-г багасгах зорилгоор иргэдийг орон сууцжуулах, түлшний хэмнэлттэй бүрэн шаталттай зуухаар хангах зэрэг ажлуудыг аймгийн хэмжээнд бодлогоор дэмжин зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгараад байна. Түүнчлэн хог хаягдал болон бусад зүйлсийг шатаах зэргээс агаарын чанарт сөргөөр нөлөөлж байгаа тул энэхүү үйл ажиллагааг аймгийн хэмжээнд бүрэн таслан зогсоох арга хэмжээ авах нь чухал юм.

1.2. Хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн орчин

Монгол улс нь 2010 онд анх Агаарын тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийг батлан мөрдөж эхэлсэн бөгөөд 2011 онд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийг баталсан. Харин 2012 онд дээрх Агаарын тухай хууль, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийг нэгтгэн Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдөж эхэлсэн байна. Одоо агаартай холбоотой дараах хууль тогтоомж, стандартууд нь хүчин төгөлдөр мөрдөгдөж, хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих, агаар бохирдуулагч этгээдэд агаарын бохирдлын төлбөр ногдуулах, төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Хууль:

- Монгол улсын үндсэн хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
- Агаарын тухай хууль
- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Журам:

- Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам
- Агаарын чанарыг сайжруулах бүс дэх түүхий нүүрсийг хязгаарлах үндсэн бүсэд орших айл өрхийг боловсруулсан түлшээр хангах нөөц бүрдүүлэхтэй холбогдуулан урьдчилгаа санхүүжилт олгох тухай журам
- Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ /ЗДХ/-г тогтоох журам
- Агаарын чанарын мэдээ гаргах журам
- Агаар бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам

ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЕ ШАТ

2.1. Хөтөлбөрийн зорилго

Агаарыг аливаа бохирдлоос хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, үүссэн бохирдлыг бууруулах, хяналт шинжилгээний ажлыг сайжруулах, бохирдуулагч нь төлөгч байх зарчмыг хэрэгжүүлэх, замаар хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, агаарыг хамгаалахад иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд хөтөлбөрийн гол зорилго оршино.

2.2.Зорилтууд

Хөтөлбөрийн зорилтуудыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

2.2.1. Хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих, агаар бохирдуулах эх үүсвэрийн тоог цөөлөх замаар агаарыг хамгаалах зохистой менежментийг бий болгоно;

2.2.2. Агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлын чанарыг сайжруулах зорилгоор техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлнэ;

2.2.3. Агаарыг хамгаалах арга хэмжээнд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, тэдэнд зөв ухамсар сэтгэлгээг төлөвшүүлнэ;

2.3.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөр, төлөвлөгөөг 2014 оноос 2024 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, САНХҮҮЖИЛТ

3.1. Удирдлага, зохион байгуулалт:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэдээллээр хангах, шаадрлагатай судалгаа, шинжилгээний ажлыг хийлгэх, хяналт тавих, хэрэгжих үе шатаар тайлагнах үүргийг аймгийн хэмжээнд Хөгжлийн бодлогын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчны газар, Ус, цаг уур, орчин шинжилгээний алба болон бусад холбогдох байгууллагууд, сумын түвшинд тухайн шатны Засаг дарга нар хариуцан ажиллана.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын зохицуулалт хийх, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, сум, багийн үйл ажиллагааны нэгдлийг хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд аймгийн тухайн шатны Засаг дарга дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр Байгаль орчны газар, Ус, цаг уур, орчин шинжилгээний алба хангаж ажиллана.

3.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтлана. Үүнд:
а/ Хөтөлбөрийг байгаль орчныг хамгаалах бусад хөтөлбөр, төлөвлөгөө, орон нутгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх;

б/ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр оролцуулах нөхцөлийг бүрдүүлж, тэдний оруулж буй хувь нэмрийг хөхүүлэн дэмжих;

в/ Хүн ам ихээр төвлөрөн суурьшсан төв суурин газар болон агаар бохирдуулах томоохон эх үүсвэр бүхий газрын агаарыг хамгаалахад түлхүү анхаарч, бохирдлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх замаар багасгаж, "Бохирдуулагч нь төлөгч байх зарчим"-ыг тууштай баримтлах;

г/ Агаарын бохирдлыг хянаж, шинжлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, агаарыг хамгаалахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

д/ Судалгаа шинжилгээ болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх бусад үйл ажиллагаанд гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх;

е/ Жил бүрийн төсөвт агаарыг хамгаалах үйл ажиллагааны зардлыг тусгаж ажиллах;

ё/ Сумын Засаг дарга нар аймгийн Засаг даргатай байгуулдаг үр дүнгийн гэрээндээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс холбогдох ажлуудыг жил бүр тусгуулан ажиллах;

ж/ Хөтөлбөрийг төр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;

3.3. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/ Агаарыг хамгаалах, хяналт-шинжилгээний арга хэмжээнд зориулан улсын болон орон нутгийн жил бүрийн төсвөөс гаргах хөрөнгө;

б/ Шинээр байгуулж буй болон ажиллаж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгжийн байгаль орчныг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулах хөрөнгө;

в/ Аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдийн хандивын хөрөнгө;

г/ Бусад төсөл, хөтөлбөрийн хөрөнгө;

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих, агаар бохирдуулах эх үүсвэрийн тоог цөөлөх замаар агаарыг хамгаалах зохистой менежментийг бий болгох зорилтын хүрээнд:

4.1.1. Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх урт, дунд хугацааны болон жил, бүрийн үндсэн чиглэлд агаарыг хамгаалахад чиглэсэн тодорхой арга хэмжээг төлөвлөн, шаардлагатай хөрөнгө санхүүг жил бүр төсөвлөж байх;

4.1.2. Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоож, бүсэд мөрдөх дэглэмийг мөрдүүлэх;

4.1.3. Агаарыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй байгальд ээлтэй, тэргүүний зөвлөмж, арга туршлага, техник, технологийг судлан орон нутагт нэвтрүүлэх;

4.1.4. Агаар бохирдлын нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, баяжуулах;

4.1.5. Төв суурин/аймаг, сум, тосгон/ газруудын нам даралтын зуухнуудыг хэсэгчилсэн болон төвлөрсөн халаалтын системд холбох замаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг цөөлөх, тэдгээрт технологийн шинэчлэлт хийж ялгаралтыг бууруулах;

4.1.6. Агаарыг хамгаалах үүднээс хог хаягдал болон дугуй бусад зүйлсийг ил задгай шатаах явдлыг таслан зогсоох, аюултай хог хаягдлыг зориулалтын зууханд шатааж, байгууламжинд устгах;

4.1.7. Тоос, утаа, тортогийг шингээн саармагжуулагч гол арга хэрэгсэл болсон мод, зүлэг, ногоон байгууламжийн нэг хүнд ноогдох талбайн хэмжээг нэмэгдүүлэх;

4.1.8. Агаарыг хамгаалахад чиглэсэн ажлуудыг санхүүжүүлэх гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах;

4.2. Агаарын чанарын хяналт, шинжилгээний ажлыг сайжруулах, техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:

4.2.1. Агаарыг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх;

4.2.2. Агаарын чанарын хяналт-шинжилгээний цэг сүлжээг өргөтгөх, мэргэжлийн байгууллага, ажилтнуудын техник хэрэгслийн хүчин чадал, төрлийг нэмэгдүүлж, хангалтыг сайжруулах;

4.2.3. Агаарыг бохирдуулах эх үүсвэр бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг дотоодын хяналт-шинжилгээний багаж хэрэгсэлтэй болгуулж, агаарыг хамгаалах хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөтэй ажиллуулан, хяналт тавих;

4.2.4. Барилга байгууламж барих, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд агаар хамгаалах зорилгоор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх явдлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хэвшүүлж, хэрэгжилтэнд хяналт тавих;

4.2.5. Агаарын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг сургаж, агаарын чанарын хяналт-шинжилгээний мэргэжлийн боловсон хүчин, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх ажлыг техник, технологийн шинэчлэлтэй уялдуулан хэрэгжүүлэх;

4.2.6. Агаар бохирдуулагч хөдөлгөөнт эх үүсвэр буюу тээврийн хэрэгсэлд экологийн магадлан оношилгоо хийлгэх ажлыг хуулиар тогтоосон хугацаанд хийж, агаар бохирдуулах түвшинг тогтоон, хянах;

4.3. Агаар хамгаалах арга хэмжээнд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдэд зөв ухамсар сэтгэлгээг төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1. Агаарыг хамгаалах бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар олон нийтийн санал хүсэлтийг байнга авах суурин утсыг ажиллуулж, мэдээллээр хангах;

4.3.2. Агаарыг хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхижүүлэх арга хэмжээ авах

4.3.3. Иргэд, олон нийтэд агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ухуулга сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4.3.4. Хот, тосгон, бусад суурин газрын агаарын бохирдлын хэмжээ, урьдчилсан мэдээг тогтмол иргэд, олон нийтэд мэдээлэх

4.3.5. Иргэдийн бүрэн шаталттай, бохирдол бага гаргадаг стандартын шаардлага хангасан зуухны хэрэглээг нэмэгдүүлж, түүхий нүүрсний хэрэглээг бууруулах

4.3.6. Агаарыг хамгаалах ажилд бохирдуулах бодис, хортой нөлөөллийг бууруулах, багасгах тэргүүний техник, технологи нэвтрүүлж тодорхой хувь нэмэр

оруулсан, шинэ санал санаачлага гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, дэмжих;

ТАВ. ХӨТӨЛБӨРӨӨС ГАРАХ ҮР ДҮН, ТҮҮНИЙГ ТАЙЛАГНАХ

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, төр, засгаас явуулж буй ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, амьд байгалийн тулгуур орчин болсон хий мандлын агаарыг цэвэр, ариун байлгаж, иргэдийн эрүүл, аюулгүй агаар орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээс гадна дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

5.1. Аймаг орон нутагт агаар хамгаалах зохистой менежмент бий болж, агаарын бохирдлын хэмжээ хүрэлцэх хэмжээнээс доош, хэвийн түвшинд хадгалагдана.

5.2. Агаар бохирдуулагч бүх төрлийн бодис, физикийн сөрөг нөлөөллийг хэмжиж, хянах техник, багаж хэрэгслийн хүчин чадал, хангамж нэмэгдэж, зөөврийн лабораторитой болно.

5.3. Түүхий нүүрсний хэрэглээ багасч, бүрэн шаталттай зуух, коксжуулсан түлшний хэрэглээ нэмэгдэж, агаар бохирдуулах эх үүсвэрүүдийн тоо буурсан байна.

5.4. Агаарын бохирдлын талаар иргэд үнэн бодит мэдээллээр тогтмол хангагдаж, тэдний агаарын бохирдлын талаарх зөв ухамсар сэтгэлгээ төлөвшиж, Агаарын бохирдлыг хэвийн түвшинд барих болон, бохирдсон агаарын бохирдлыг бууруулахад иргэд олон нийтийн идэвхи оролцоо нэмэгдэнэ.

5.5. Аймгийн хэмжээнд агаарын бохирдолттой холбоотой нэгдсэн мэдээллийн сантай болно.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны Засаг дарга үе шат тус бүрээр 4 жил тутамд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Хуралд, эцсийн /2014-2024 он хүртэлх/ хэрэгжилтийг 2025 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

----oO-----